



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 5/131

Улаанбаатар хот

Албан тушаалд томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.3, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.9, Сангийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/2676 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Дундговь аймгийн татварын хэлтсийн удирдах албан тушаалд нэр дэвшсэн Чинбатын Оюунжаргалыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн даргын, Шатарын Мөнгөнцэцэгийг Захиргаа, хуулийн тасгийн даргын, Баасангийн Жанчивдоржийг Татварын хяналт шалгалтын тасгийн даргын албан тушаалд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс томилсугай.

2. Тасгийн дарга Ч.Оюунжаргал, Ш.Мөнгөнцэцэг, Б.Жанчивдорж нарын албан тушаалын цалин, нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Дундговь аймгийн татварын хэлтэс (М.Туяацэцэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151605121